

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
М.ЭРДЭНЭЧИМЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1		2	3	4	5	6	7	
Зорилт 1. "ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.	Арга хэмжээ 1.1. Иргэдийг сэргийлэх шинжилгээнд эрт илрүүлэг, мэндийн оношилгоонд хамрагдах явц мэдээллийг нэгтгэж ажиллах;	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	85	40	Өрхийн эрүүл мэндийн төвүүд 75438 хүнд үзлэг хийснээс 33024 хүн буюу нийт үзлэгийн 43,7 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. 2024 оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 14789 иргэн хамрагдахаас 12250 буюу 82.8 хувь нь хамрагдаж, 24 тохиолдол, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 11070 иргэн хамрагдахаас 9820 буюу 88.7 хувь нь хамрагдаж, 5 тохиолдол, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 8255 хүн хамрагдахаас 7149 хүн буюу 86,6 хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 1821 иргэн хамрагдахаас 1353 буюу 74,2 хувь нь хамрагдаж, эрт илрүүлгийн үзлэгийн дундаж хамрадалт 82.9 хувьтай байна. Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төв Рафазл Интернэйшнл олон улсын байгууллагын 42 хүний бүрэлдэхүүнтэй багийг урьж, зорилтот бүлгийн 400 гаруй иргэнд дотор, бөөр, дотоод шүүрэл, зүрх, нүд, шүд, урологи, чих хамар хоолой, эхо, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нар 14 төрлийн үзлэг, оношилгоо, шинжилгээг хийж, эм тариаг үнэ төлбөргүй олгосон. Улс	2024.01.02 2024.12.31	100	

					орон даяар явагдаж буй эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд Арвайхээр сумын 30352 иргэн хамрагдсанаас эрэгтэй-13349, эмэгтэй-17003, 0-5 насны хүүхэд 2439 6-17 насны 8706, 18-30 насны 4302, 31-45 насны 6460, 46-60 насны 5931, 61-с дээш насны 2514 иргэн хамрагдаж, нийт иргэдийн 81,6 хувь нь хамрагдаж өмнөх оноос 33,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үзлэгт хамрагдсан 18 дээш насны хүн амын дунд хоол боловсруулах эрхтэн, дотоод шүүрэл, шээс бэлгийн зам, зүрх судасны тогтолцоо, амьсгалын замын өвчлөл тэргүүлж байна. Хорт хавдрын шалтгаанаар 30 иргэн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 20 хувиар өссөн бол шинээр 51 иргэн бүртгэгдэж батлагдсан нь өмнөх оноос 13 тохиолдол буюу 20,3 хувиар, буурсан үзүүлэлттэй байна.		
2	Арга хэмжээ 1.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран үр нөлөөтэй зохион байгуулах	Танхимаар зохион байгуулсан сургалтын тоогоор	14	8	“Өсвөр насны охидын сэтгэл зүй”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт”, “Цахим орчны зохистой хэрэглээ”, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлье”, БЗХӨ -өөс урьдчилан сэргийлэх нь зэрэг танхимын сургалтад 1800 хүүхэд хамрагдаж, 16 төрлийн мэдээллийг цахим хуудсанд байршуулж 6117 иргэний хандалт авсан.Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, өдөрлөг, нөлөөллийн 49 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 7501 иргэнийг хамруулсан байна. Жирэмсэн эхчүүдэд ганцаарчилсан зөвлөгөө, амбулаторийн сургалт, Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Гавьяатуудаа сонсьё”, “Хамгаалах нь эмчлүүлэхээсээ чухал” зорилтот арга хэмжээнд төрийн болон төрийн	2024.01.02 2024.12.01	100

					бус байгууллагуудын ажилтан албан хаагчид, 13 багийн иргэдийн төлөөлөл 300 гаруй иргэдийг оролцуулж, мэдээлэл зөвлөгөө өгсөн. 43 төрлийн нийт 650 ширхэг гарын авлагыг иргэдэд түгээж, мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэн ажилласан. Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн боловсрол олгох 5 цуврал комикс номыг цахим хэлбэрээр бэлтгэн гаргаж, иргэдэд хүргэсэн.			
		2.цахимаар сургалт мэдээлэл авсан иргэдийн хандалтын тоо	13		Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн пэйж хуудас нь 3478 дагагчтай пэйж хуудсаар нийт 398 удаагийн мэдээ, мэдээлэл, 21 төрлийн постер, 26 видео шторк бэлтгэн байршуулж, 240689, Нарны дөш эмнэлэг халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх 82 сэдвийн хүрээнд 324 төрлийн мэдээлэл, зөвлөгөөг нийтэлж, давхардсан тоогоор 19563, Түшиг дөлгөөн ӨЭМТөв 373 мэдээ, мэдээлэл бэлтгэн, 61851, нийт 3 өрхийн мэндийн төвийн цахим хуудсаар 2442 удаагийн эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл иргэдэд хүргэж, 304440 хүний хандалт авсан байна.	2024.01.02 2024.12.01.	100	
3	Арга хэмжээ 1.3. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хорт зуршил, мансууралтай тэмцэх талаар сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	10		Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл гутрал, уур бухимдлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх, стрессийг даван туулах аргууд, стресс тайлах цэгэн бариа, амьсгалын дасгалууд гэх мэт 48 төрлийн мэдээлэл, 6 төрлийн видео зөвлөмж, 8 төрлийн постерыг байгууллагын болон орон нутаг идэвхтэй ажилладаг фэйсбүүк группт нийтэлснээр давхардсан тоогоор 15389 хүн хандаж мэдлэг, мэдээллээр хангагдсан байна. Өсвөр үе, ахлах ангийн сурагчдад зориулсан нийт 14	2024.01.02 2024.12.01	100	

						удаагийн танхимын сургалтыг архи тамхины хор уршиг, электрон тамхины хор уршиг, сэтгэл зүй сэдвүүдээр зохион байгуулж, нийт 600 гаруй хүүхдийг хамруулсан байна. Арвайхээр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Электрон тамхинаас татгалзъя” богино хэмжээний видео контентыг Соёмбо телевизтэй хамтран хийж, 18 shage 2900 хүний хандалт авсан байна. “Уян сэтгэл” өрхийн эрүүл мэндийн төв БОЭТ-ийн Сэтгэц-Наркологийн тасагтай хамтран донтох эмгэгийн талаар цуврал подкаст бэлтгэн хүргэж 10000 хүнд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс бэлтгэн гаргасан “Ахмад настны сэтгэл зүй”, “Жирэмсэн үеийн сэтгэл зүйн өөрчлөлт”, “Айдас ба сэтгэл түгшилт”, “Архинд донтох сэтгэцийн эмгэг мөн үү”, “Сэтгэл гутралаас гарах аргууд”, “Сэтгэц нөлөөт эм ба эмийн гаж нөлөө гэж юу вэ” 6 цуврал видео мэдээллийг байгууллагын пэйж хуудаст нийтлэн 14000 хүнд хүргэсэн. Сумын хэмжээнд архины хамааралтай 186 иргэн байгаа нь өмнөх жилээс 64 хүнээр буюу 9,2 хувиар буурсан үзүүлэлтэй байна. “Архи ба түүний хор нөлөө” “Хорт зуршлаас сэргийлэх нь” сэдэвт сургалтад архины хамааралтай 59 иргэнийг хамруулж, 9 иргэнийг түр ажилд холбон зуучилж ажиллуулсан бол бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц наркологиын тасагт 13, Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал” нийгмийн сэргээн засах төвд 2 иргэнийг тус тус 7-10 хоног хэвтүүлэн эмчлүүлсэн. Аймгийн гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын газартай хамтран Дорнод аймгийн “Ухаарал” эмнэлэгт архинаас гаргах
--	--	--	--	--	--	--

					эмчилгээ, үйлчилгээнд Арвайхээр сумаас 3 иргэнийг хамруулж, эмчилгээ хийлгэсэн. Багийн нэгдсэн төв, 2.3-р багийн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөөгөөр 276 иргэн үйлчлүүлж, зөвлөгөө мэдээлэл авсан.			
4	Арга хэмжээ 1.4. Цэргийн насны эрчүүдийг эрүүлжүүлэх ажлын явц, үр дүнг тооцож, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах;	Зөвлөлийн хуралд танилцуулж, тайлагнасан байна	1	2	2024 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагаар нийт 1239 залуучуудын судалгааг шинэчлэн гаргаж үүнээс биеэр 692 залуу ирж эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас 300 буюу 43,4 хувь нь эрүүл мэндээр тэнцэж, 392 буюу 56,6 хувь нь өвчлөлтэй гарсан. Өвчлөлийн 23,4 хувь нь дотрын, 15,8 хувь нь мэс заслын, 11,7 хувь нь гэмтлийн, 10,4 хувь нь чих, хамар хоолойн, 9,6 хувь нь нь нүдний, 8,9 хувь нь мэдрэлийн, 8,1 хувь зүрх судасны, 2,0 хувь нь сэтгэцийн, 1,7 хувь нь арьс харшлын, 1,4 хувь нь сүрьеэгээр 6,8 хувь нь бусад өвчлөлөөр өвдсөн үзүүлэлттэй байна. Эмчлэгдэх боломжтой оноштой залуучуудад өрхийн эрүүл мэндийн төвүүд эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийж байна. Бэлгийн замын халдварт өвчний 7 тохиолдлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлсэн. 2 удаагийн цэрэг татлагаар 49 залуу эрүүл мэнд, бие бялдраараа тэнцэж цэргийн жинхэнэ албыг хааж байна. Цэргийн насны залуучуудын эмчлэн эрүүлжүүлэлтийн тайлан, мэдээг ppt хэлбэрээр бэлтгэн танилцуулсан.	2024.01.02 2024.12.01	100	
5	Арга хэмжээ 1.5. Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	2	Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвүүд болон холбогдох байгууллагуудтай хамтран 15 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 6090 хүнд хийж лабораторийн шинжилгээнд 2687 иргэнийг хамруулснаас 678 иргэн өвчлөлтэй гарсан. Оношилгоонд	2024.01.02 2024.12.01	100	

					хамрагдсан иргэдээс өдрийн эмчилгээнд 1133, уламжлалтын эмчилгээнд 333, сэргээх засах тусламж үйлчилгээнд 417 эрэгтэйчүүдийг тус тус хамруулж эмчлэн эрүүлжүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах сэдвийн хүрээнд "Нөхөн үржихүй-Гэр бүл төлөвлөлт", "БЗДХ-аас сэргийлье", "Эрэгтэйчүүдийн дунд зонхилох өвчин, Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлцгээе", "Архи ба эрүүл мэнд", "Тамхинаас үүсэх эрсдэлүүд", "Биеийн жингийн индексээ хэмжиж суръя", "Эрчүүдийн бэлэг эрхтний эрүүл ахуй зэрэг сэдвээр 10 удаагийн танхимын сургалтад 750 гаруй иргэн, "Эрт илрүүлж- Эрсдэлээс сэргийлье өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 250 иргэн хамрагдаж мэдээлэл авсан бол цахим хуудсанд өвчлөлийн дийлэнх хувийг эзэлж байгаа зүрх судасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл, "БЗДХ-аас сэргийлье", "Эрэгтэйчүүдийн дунд зонхилох өвчин-Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлцгээе", "Архи ба эрүүл мэнд", "Тамхинаас үүсэх эрсдэлүүд" зэрэг нийт 39 төрлийн мэдээллийг байршуулахад 6777 иргэний хандалтыг авсан. 2024 оны цэрэг татлагаар 692 залуу эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас 300 буюу 43,4 хувь нь эрүүл мэндээр тэнцэж, 392 буюу 56,6 хувь нь өвчлөлтэй гарсан. Өвчлөлийн 23,4 хувь нь дотрын, 15,8 хувь нь мэс заслын, 11,7 хувь нь гэмтлийн, 10,4 хувь нь чих, хамар хоолойн, 9,6 хувь нь нь нүдний, 8,9 хувь нь мэдрэлийн, 8,1 хувь зүрх судасны, 2,0 хувь нь сэтгэцийн, 1,7 хувь нь арьс харшлын, 1,4 хувь нь сүрьеэгээр 6,8 хувь нь бусад өвчлөлөөр өвдсөн
--	--	--	--	--	---

						үзүүлэлттэй байна.Эмчлэгдэх боломжтой оноштой залуучуудад өрхийн эрүүл мэндийн төвүүд эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийж байна. Бэлгийн замын халдварт өвчний 7 тохиолдлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлсэн.			
						Гэр бүл төлөвлөлт, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдах талаарх 12 удаагийн зөвлөгөө, мэдээллийг цахимаар байршуулж, 7545 гаруй хүний хандалт авсан. БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдахын ач холбогдол бүхий 11 төрлийн гарын авлагыг 2966 хүнд хүргэсэн. "Нөхөн үржихүй", "БЗДХ-ын тухай, түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт танхимын сургалтыг 11 удаа зохион байгуулж, 1116 иргэн хамрагдсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд эхний 10 сарын байдлаар цэргийн насны залуучууд, уул уурхайд ажиллагсад, өсвөр нас, жирэмсэн, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг зорилтот бүлгийн 3372 хүнийг ХДХВ, ТРНА илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулсан ба хамрагдалт өмнөх жилээс 36 хувиар нэмэгдсэн. Шинжилгээгээр тэмбүү 44 тохиолдол батлагдсан нь өмнөх жилээс 24 тохиолдлоор буюу 35,2 хувиар, трихомониаз 3 тохиолдол, өмнөх жилийн мөн үеэс 1 тохиолдлоор буюу 0,75 хувиар буурч, Гонококкт 24 тохиолдол батлагдаж 2023 оноос 1 тохиодлоор буюу 0,96 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Батлагдсан тохиолдлуудыг хяналтад авч, 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн. БЗДХ өвчин 10000 хүн амд ногдох халдварт өвчний продецимилиэр 13,3 болж буурсан үзүүлэлттэй байна.	2024.01.02 2024.12.01	70	
6	Арга хэмжээ 1.6. БЗХӨ /ДОХ тэмбүү/ өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	2					

7	Арга хэмжээ 1.7 Байгууллагын эрүүл мэндийн хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын хувь	100	100	Түшиг дөлгөөн өрхийн эрүүл мэндийн төвд Улаанбаатар хотоос шим судлаач эмч нарын баг ирж ажилласан бөгөөд тус багийн эмч нарыг байгууллага дээрээ урьж авчран байгууллагын болон Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нийт 50 албан хаагчийг эрдсийн шинжилгээнд хамруулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрэгтэйчүүдийн эмч Б.Ганзориг эмчид байгууллагын 28 эрэгтэй албан хаагчаас 21 буюу 75 хувь нь үзүүлэн түрүү булчирхайн хавдрын эс илрүүлэх шинжилгээ, эхо, болон холбогдох шинжилгээнд хамруулж үзлэг оношилгоог хийлгэж, эмчилгээ бичүүлж, зөвлөгөө заавар авсан. Эмэгтэй албан хаагчдыг эмэгтэйчүүдийн PCR болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 30 албан хаагч буюу 57,6 хувь нь хамрагдаж, зөвлөгөө заавар авч шинжилгээний хариуны дагуу зарим албан хаагчид өдрийн эмчилгээ бичүүлж гадуур стор нээлгэж шаардлагатай эм, эмчилгээ хийлгэсэн. БОЭТөвийн Дэмжих төвд байгууллагын албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулах ажлыг 2 удаа зохион байгуулан 35 албан хаагч хамрагдсан ба 44,3 хувь нь эрт илрүүлэгт хамрагдсан бол 55,7 хувь дахин хамрагдах хугацаа болоогүй байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Уламжлалтын тасагт 3 Нийгмийн ажилтныг 7 хоног хэвтүүлэн эмчлүүлсэн. 4 албан хаагчид 2,800,000 төгрөгийн эмчилгээний дэмжлэг үзүүлсэн байна.	2024.01.02 2024.12.01	100
8	Арга хэмжээ 1.8. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдийг төрийн	эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоогоор	-	50	Сумын хэмжээнд эхний 11 сарын байдлаар 186 иргэн байгаа нь өмнөх жилээс 64 хүнээр буюу 9,2 хувиар буурсан үзүүлэлтэй байна. “Архи ба түүний хор нөлөө” “Хорт зуршлаас	2024.01.02 2024.12.01	100

болон сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах	сэргийлэх нь” сэдэвт сургалтад архины хамааралтай 59 иргэнийг хамруулж, 9 иргэнийг түр ажилд холбон зуучилж ажиллуулсан бол бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц наркологиын тасагт 13, Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал” нийгмийн сэргээн засах төвд 2 иргэнийг тус тус 7-10 хоног хэвтэн эмчлүүлж эмчилгээний зардал болох 2,365,825 төгрөгийг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гаргаж эмчлүүллээ.Аймгийн гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын газартай хамтран Дорнод аймгийн “Ухаарал” эмнэлэгт архинаас гаргах эмчилгээ, үйлчилгээнд Арвайхээр сумаас 3 иргэнийг хамруулж, сургалт мэдээлэл, зөвлөгөө заавар өгч, эмчилгээ хийлгэсэн.				
Зорилт 2. “НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ИРГЭДИЙГ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТ ТӨЛӨВШҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1 Арга хэмжээ 2.1. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил” өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Биеийн тамир спортын салбарын түүхт 100 жилийн ойн хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт уриалсан олон талт арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Зохيون байгуулсан арга хэмжээний тоогоор	15	7	2024.01.02 2024.12.01	100
Аймгийн Биеийн тамир спортын газар, бусад холбогдох байгууллага, спортын холбоо, клубүүдтэй хамтран “Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд” уриан дор өглөөний дасгал, гүйлт, алхалт, фитнес, спиннинг, хийн дасгал, бүжиг зэрэг төрөлд давхардсан тоогоор 5040 иргэнийг хамруулсан. Үүнд: “Зөв цаг клуб”-тэй хамтран Нийтийн бүжгийн 7 хоногийн аян, Шугаман бүжгийн 7 хоногийн аян, Ахмадын хороотой хамтарсан хийн дасгалын 7 хоногийн аян Мөрөөдөл 160 Спиннинг, жамп клубтэй хамтарсан 7 хоногийн аяныг тус бүр зохион байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Арвайхээр хотын аварга шалгаруулах “Нийтийн цэнгээнт бүжгийн тэмцээн”-ийг 4					

103

					насны ангилалд 60 бүжигчин, Далантүрүү дартсын клубтэй хамтран "Дартс"-ын тэмцээнийг 6 төрлөөр зохион байгуулж, 146 тамирчин оролцсон. Өвөрхангай аймгийн шатрын холбоотой хамтран насанд хүрэгчдийн Шатрын аварга шалгаруудах тэмцээн, Төрийн үйлчилгээ мэдээллийн төв үүсэн байгуулагдсан өдрийг тохиолдуулан хамтрагч байгууллагуудын дунд Волейболын тэмцээн, байгууллагын албан хаагчдын дунд Дартс, Ширээний теннис, гар бөмбөгийн тэмцээн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 4 төрөлт тэмцээн болон Арвайхээр сумын хэмжээнд боловсролын байгууллагуудын ажилтан албан хаагчдын болон байгууллагын аварга шалгаруулах спортын тэмцээн, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан тэмцээн уралдаан зэрэг 134 удаагийн тэмцээн уралдаанд давхардсан тоогоор 7316 хүн оролцсон байна.		
2	Арга хэмжээ 2.2. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалнууд 7 хоногийн 1 өдөр үнэ төлбөргүй үйлчлэх боломжийг судлан, хэрэгжүүлэх	Заалны тоогоор	6	6	Засаг даргын захирамжаар хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөв, дадал бий болгох зорилгоор ЕБСургуулиудын спорт заалыг өглөө 06:00-08:00 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй үйлчилдэг болсон ба энэ хүрээнд ЕБ-ын 6 сургуулийн 8 спорт зааланд давхардсан тоогоор 10000 гаруй хүүхэд багачууд 200 гаруй иргэн өглөөний цагаар сургуулийнхаа болон гэртээ ойр сургуулийн зааланд тоглон өөрсдийн амьдралдаа идэвхтэй хөдөлгөөн хийж эрүүл амьдралын зөв дадал хэвшилд суралцаж байна.	2024.01.02 2024.12.01	100

3	Арга хэмжээ 2.3 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч үр дүнг тооцох	Бие баялдын сорилд хамрагдсан иргэдийн хувь	100	26	Бие бялдын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2024 оны 04 дүгээр сарын 29- оос 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд болон 10-11 сард 2 удаа зохион байгуулж, 13 багийн 15-64 насны иргэд болон худалдаа үйлчилгээний төвийн албан хаагчид нийт 1109 иргэнээс авч дүнг нэгтгэхэд эрэгтэй-601, эмэгтэй 508 иргэн хамрагдсан ба Үүнээс А, В, С, D, F үнэлгээгээр авч үзвэл А-198, буюу 17,9%, В-145 буюу 13,1% С-215 буюу 19,3% D- 305 буюу 27,5%, F-246 буюу 22,1% үнэлгээтэй байна. Сорилд хамрагдсан насанд хүрэгчдийг биеийн жингийн индексээр авч үзвэл: Туранхай-55 буюу 4,9%, Хэвийн жинтэй-611 буюу 55,0%, Илүүдэл жинтэй-443 буюу 39,9 хувь нь илүүдэл жинтэй, таргалалттай байна. Сорилд хамрагдсан нийт иргэдийн биеийн жингийн индекс, хөгжлийн түвшнийг тодорхойлж, иргэд болон албан байгууллагуудад зөвлөмж өгч, тухайн зөвлөмжийг мөрдөн ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж байх уриалгыг өгсөн. Ерөнхий боловсролын 6 сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 14 цэцэрлэг хүүхдүүдээс бие бялдын сорилыг авч тус бүрдээ нэгтгэн аймгийн Биеийн тамир спортын газарт хүргүүлсэн.	ф	100
4	Арга хэмжээ 2.4 Спортын төрлүүдээр сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах;	Спортын арга хэмжээ зохион байгуулагдс ан байна	4	5	Арвайхээр хотын аварга шалгаруулах Нийтийн бүжгийн тэмцээн, Дартсын тэмцээн, ахмад настуудын дунд Хийн дасгалын тэмцээн, Арвайхээр лиг сагсан бөмбөгийн тэмцээн, Шатрын тэмцээн, Ирээдүйн Аварга бөхийн цуврал барилдаан, Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат тамирчин, даяар дурсагдах далай даян, дархан аварга Дашдоржийн Цэрэнтогтохын нэрэмжит	2024.01.02 2024.12.01	100

					хүүхдийн үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээн, Төрийн үйлчилгээ мэдээллийн төв үүсэн байгуулагдсан өдрийг тохиолдуулан хамтрагч байгууллагуудын дунд Волейболын тэмцээн, байгууллагын албан хаагчдын дунд Волейбол, Дартс, Ширээний теннис, Буухиа тэмцээн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 4 төрөлт тэмцээн, нийт 12 тэмцээнийг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 1866 хүнийг хамруулсан. Бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох эрх авсан 8 тамирчинд 5,4 сая, бүжгийн 3 хамтлагт 11,4 сая, 3 клубийн баг тамирчдад 6,0 сая нийт 22.7 сая төгрөгийн дэмжлэгийг, 3 Төрийн бус байгууллагын зохион байгуулсан үйл ажиллагаанд 6,0 сая, сумын Засаг даргын нэрэмжит болон Засаг даргын Тамгын газар, бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаанд 22,8 сая төгрөгийг тус тус Засаг даргын нууц хөрөнгөөс олгож зарцуулсан байна.	
“Зорилт 3 “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
1	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах	Спортын арга хэмжээ зохион байгуулагдс ан байна	1	1	“Эх дэлхий –Элгэн нутаг” зорилтот байгаль хамгааллын өдөрлөг арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй 128 иргэн оролцож, Байгаль орчны өнөөгийн байдал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар болон байгаль эх дэлхийтэйгээ хэрхэн зөв харьцах, уур амьсгалын өөрчлөлт бидний амьдралд хэрхэн нөлөөлж байгаа иргэд бид түүнийг яаж даван туулах, өөрсдийн хэмжээнд эерэг хандлагыг төлөвшүүлэх тухай мэдээлэл хүргэж мэдлэг олгосон эм гоо эмийн сангаас эмийн багцыг оролцогчдод олгосон.Олон улсын	2024.01.02 2024.12.01 100

					эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ерэн есөн сарнай” сургалт нөлөөллийн болон баярын арга хэмжээг 13 багийн хөгжлийн төлөөл 99 эмэгтэйг эмэгтэйчүүдийн төлөөл АПАУ нийгэмлэгийн оролцуулсан. АПАУ нийгэмлэгийн төлөөлөгчийн баг Арвайхээр суманд ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэд, холбогдох албаны хүмүүст “Аутизмтай хүүхдийг танин мэдэхүй ба харилцах нь” сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон аутизмтай хүүхдүүдийн асран хамгаалагч 50 гаруй иргэд хамрагдаж мэдээлэл авсан. “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн ажлын хүрээнд цахим ур чадварыг олгох, болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, 47 иргэн хамрагдлаа. Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төв Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эм гоо ХХК хамтран “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагатай зорилтот бүлгийн иргэд болон асран хамгаалагч нарын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нь” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж өдөрлөгөөр 65 иргэн оролцож артерийн даралт хэмжиж, биеийн жингийн индекс тодорхойлж хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа, сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, нийгмийн халамжийн төсөл хөтөлбөрүүд эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний талаар сургалт зохион байгуулсан. “Бүтээлч гар холбоо НҮТББ”-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Сонгогчийн боловсрол олгох 2 удаагийн сургалтыг зохион байгуулж
--	--	--	--	--	--

					давхардсан тоогоор 100 гаруй иргэн хамрагдсан. Амьдрах ухааны сургалтад 8, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 10, өдрийн болон сэргээн засах үйлчилгээнд 15, бүлийн төсөлд 2, нийт 416 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан. Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд уриан дор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 4 төрлийн тэмцээнийг зохион байгуулж, 50 гаруй иргэд идэвхтэй оролцлоо. "Эрүүл монгол хүн" бүх нийтийн гүйлт-2024 тэмцээнд гүйлт, тэргэнцэртэй гүйлт гэсэн 2 төрөлд оролцож 8 медаль авч амжилттай оролцсон. Монголын тусгай олимпын хорооны ажлын хэсэг Өвөрхангай аймагт ажиллаж "Боломжийг бүгдэд" төслийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж хангайн бүсийн 6 аймгийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оюуны онцлогтой хүүхдүүд, тэдний эцэг эх асран хамгаалагч 260 гаруй төлөөлөгчид оролцсон арга хэмжээнд сумын оюуны онцлогтой хүүхдүүд, асран хамгаалагч нарыг оролцуулж зохион байгуулалтад хамтран ажилласан. Тус арга хэмжээнд оролцсон 6 аймгийн 75 хүүхдэд Засаг даргын Тамгын газраас 2 сая төгрөгийн гарын бэлэг өгсөн. "Амардэлгэрийн-Ээл" НҮТББ санаачлан зохион байгуулж буй "Сэтгэлд Мандсан нар жаргадаггүй" зорилтот хувь хүн хөгжүүлэх өдөрлөгийн арга хэмжээнд 1,5 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг утган зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих "Урлагийн нэгдсэн арга хэмжээ"-нд 10 иргэн ардын урлагийн төрөл болон Гоцлол дуу, шүлгээр
--	--	--	--	--	--

					оролцож 3 иргэн шагналт байр 1 иргэн ардын урлагийн төрлөөр Тэргүүлж Улаанбаатар хотод зохион байгуулагдах "Тэгш дүүрэн" үндэсний хэмжээний фестивалд оролцох эрх авч Арвайхээр сумын оролцогчид амжилттай оролцсон.....		
2	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг нэмэгдүүлнэ.	Хүртээмжтэй орчин бий болгосон байгууллага, аж ахуйн нэгжийн тоогоор	8	7	"Бүтээлч гар" ТББ, Арвайхээр тэргэнцэртэй иргэдийн холбоо, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Стандарт хэмжил зүйн газартай хамтран 21 аж ахуйн нэгж байгууллага, Арвайхээр хотын төв талбай, баруун 4 зам болон 11 зам гарц зэрэгт хүртээмжийн үнэллэг орчны хүртээмжийн үнэлгээ хийж, 75 хувь нь хангалтгүй үнэлэгдэж байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгууллага, аж, ахуй нэгж, хариуцсан эрх бүхий хүмүүст зөвлөмж хүргүүлсэн. Үнэлгээ хийгдсэнээр энэ онд төрийн байгууллага хувийн хэвшил, худалдааны үйлчилгээний төвүүд дэлгүүр зэрэг 22 газар хүртээмжтэй болж өмнөх оноос 50 хувиар өссөн байна. Бүтээлч гар холбоо НҮТББ"-д Төрийн болон ААН, байгууллагууд болон гудамжны гэрэлтүүлэг, явган замуудад хүртээмжийн үнэлгээ хийх ажилд дэмжлэг үзүүлж 1,5 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хөндсөн телевизийн нэвтрүүлэг, шторк хийх ажилд 1,0 сая төгрөгийн үзүүлсэн.	2024.01.02 2024.12.01	100
Зорилт 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт	Тайлан мэдээний биелэлтийн хувь	100	100	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулан батлуулж хагас, бүтэн жилээр, сумын Сумын иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт болон бусад хугацаатай	2024.01.02 2024.12.01	100

	бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;					тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.		
	Арга хэмжээ 4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн албан байгууллага, тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	100	100	100	2024 оны жилийн эцсийн байдлаар 25 захирамжийн төсөл боловсруулан, 3 албан бичиг төлөвлөн, 17 албан бичиг ирснээс 11 хариутай албан бичгийг цаг хугацаанд нь хариуг албан тоотоор болон цахимаар хүргүүлсэн.	2024.01.02 2024.12.01	100
2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм чандлан сахиж, төрийн албан хаагчийн хувьд хариуцсан ажилдаа хариуцлагатай, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хувийн зохион байгуулалтаа сайжруулах талаар анхааран ажиллаж, байгууллагын дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих ажилласан эсэх	0	0	0	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, төрийн албан хаагчийн хувьд хариуцсан ажилдаа хариуцлагатай, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хувийн зохион байгуулалтаа сайжруулах талаар анхааран ажиллаж, байгууллагын дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн.	2024.01.02 2024.12.01	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2024 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах	Тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах		100	2024 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсэгт 7 хоног ажилласан.	2024.01.02 2024.12.01	100

2	Байгууллагын хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	100	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн хамт хөтөлбөр гаргаж дагуу ажилттай зохион байгуулсан.	2024.01.02 2024.12.01	100
3	2024 оны 1, 2-р ээлжийн цэрэг татлагаар цэргийн албанд тэнцсэн цэргүүдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	Цэргүүдийг үзлэг шинжилгээн д бүрэн хамруулах	100	1,2 дугаар ээлжийн цэрэг татлагад эрүүл мэнд бие бялдраараа тэнцсэн 49 залууг БОЭТ-д 8 төрлийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж үзлэг шинжилгээнд хугацаанд бүрэн хамруулж хуваарьт цэргийн ангиудад нь хүлээлгэн өгч цэргийн жинхэнэ албанд мордуулсан.	2024.01.02 2024.12.01	100
4	Тендерийн үнэлгээний хороонд ажиллах	Хууль журмын дагуу зохион байгуулах	100	Өндөр гэгээн Занабазар музейг засварлах ажлын үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж тендерийг хууль журмын дагуу зохион байгуулан ажиллаж холбогдох материалыг Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.	2024.04.25 2024.12.01	100
5	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн ажлын хэсэг	Зохион байгуулсан арга хэмжээ	100	Эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг ханган тайлан мэдээг гарган ажилласан.	2024.05.29 2024.12.01	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. Архив албан хэрэг хөтөлөлтийн чиглэлээр цахим болон онлайн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдаж сертификат авсан байна.			Архив албан хэрэг хөтөлөлтийн 10 хоногийн цахим сургалтад хамрагдаж сертификат авсан.	2024.01.02 2024.12.01	100
2.	Арга хэмжээ 2.2. Монгол хэл бичгийн дунд шатны цахим хичээлийг бие даан судлан	Сургалтад суралцаж батламж,	-	50	Үндэсний бичгийн 18 цагийн сургалтад хамрагдаж	2024.01.02 2024.12.01	100

суралцаж дээшлүүлсэн байна.	мэдлэг	чадвараа	гэрчилгээ байна.	авсан	№2024032207 сертификат авсан.	дугаартай	
--------------------------------	--------	----------	---------------------	-------	----------------------------------	-----------	--

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН  ТАЙЛАН ГАРГАСАН:
М.ЭРДЭНЭЧИМЭГ

2024 оны 11 дүгээр сарын 25